

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 9 сарын 11 өдөр

№ R-2024-43

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны ТУЗ-ийн 2024 оны 9 дүгээр сарын 05-11-ний өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") нь 2024 оны 9 дүгээр сарын 05-11-ний өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнд, Банкны эрх бүхий албан тушаалтанд олгох, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий нийт 20,000,000 (хорин сая) төгрөгийн үнийн дүнтэй (кредит карт сунгах) хэлцэл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл")-ийг Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалт, 4.3 дахь хэсэгт заасны дагуу батлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй ердийн нөхцөлөөс давуу тал олгоогүй болохыг ЭУХ тодорхойлсон болохыг; мөн
- ТУЗ нь ЭУХ-ноос санал болгосны дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Тогтоолын хавсралтад заасан Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсугай.
- Хэлцлийн нөхцөлд аливаа материаллаг өөрчлөлт ороход ТУЗ-өөр батлуулахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Вэб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn



ХАСБАНК ХК

Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан талаарх мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000239852 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00XAC05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-мэйл: info@xacbank.mn Вэбсайт: www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Н.Цэлмэгхишиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан талаарх мэдээлэл	
ХасБанк ХК ("Банк")-ийн ТУЗ-ийн 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн R-2024-43 дугаар тогтоолоор, Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу, Банкны эрх бүхий албан тушаалтантай байгуулсан нийт 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн үнийн дүн бүхий 1 (нэг) хэлцлийг баталсан болно. Энэхүү хэлцэл нь Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд олгогдсон, гуравдагч этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг хангасан болно.	

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Огноо: 2024 он 9 сар 13 өдөр